

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ӨМЧИЙН ХЯНАЛТ, АШИГЛАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

2024 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 20 захирамжийн 23 заалтын хэрэгжилтийг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсээс 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хүлээн авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3 заасан аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

1.Захирамжийн бүртгэл

Тайлант хугацаанд нийслэлийн Засаг даргын 20 захирамжийг бүртгэн авч “Хяналтын карт” хөтлөн удирдлагад танилцуулан цохолт хийлгэн Өмчийн менежментийн хэлтэс (10), Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс (10) шилжүүлсэн байна.

2.Захирамжийн хэрэгжилт

Нийслэлийн Засаг даргын 20 захирамж хяналтад авснаас нийслэлийн өмчит төсөвт байгууллага, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн **100.1 тэрбум** төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөн бүхий бүртгэх 13, хөрөнгө данснаас хасах 1, балансаас баланст шилжүүлэх 3 захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллуулахаар холбогдох байгууллагад албан бичиг хүргүүлсэн, захирамжаар байгуулсан холбоотой 3 ажлын хэсэгт орж санал хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

Тээврийн хэрэгсэл бүртгэх

2024.01.16 А/49 захирамж (2.1 тэрбум төгрөгийн 9 тээврийн хэрэгсэл)	- СХД-ийн “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ-т 18.6 сая төгрөгийн 2 ш суудлын тээврийн хэрэгсэл, - “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ-т 2.0 тэрбум төгрөгийн 7ш хог шахагч автомашин
2024.01.19 А/85 захирамж (63.7 тэрбум төгрөгийн 231 автобус)	- НЗДТГ-т бүртгэх Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нэг бүрийн үнэ 275.9 сая төгрөгийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус
2024.01.22 А/89 захирамж (733 сая төгрөгийн 1 хүнд даацын тээврийн хэрэгсэл)	- УСУГ ОНӨААТҮГ-т Тайван улсын Хүүхэд гэр бүлийн дэмжих сангаас хандивласан Dong Fend маркийн тээврийн хэрэгсэл
2024.02.07 А/147 захирамж (30.0 сая төгрөгийн 1 жижиг тэрэг)	- СБД-ийн ОБХ-т Саплай чен ХХК-ын буцалтгүй тусламжаар Nissan Elgrand E-50 маркийн жижиг тэрэг

2024.02.13 A/160 захирамж (60.2 тэрбум төгрөгийн 218 автобус)	- НЗДТГ-т бүртгэх Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нэг бүрийн үнэ 275.9 сая төгрөгийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус
2024.03.01 A/217 захирамж (347.7 сая төгрөгийн 1 тусгай зориулалтын, 8 суудлын автомашин)	- ХУД-ийн ОБХ-т 1 ш 20.0 сая төгрөгийн тусгай зориулалтын автомашин, - Нийслэлийн Эрүүл мэндийн газарт 22.5 сая төгрөгийн 1 ш суудлын автомашин, - Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт 218 сая төгрөгийн 2ш суудлын автомашин, - БХД-ийн ЗДТГ-т 32.7 сая төгрөгийн 1 ш суудлын автомашин, - СХД-ийн “Отгон долоон бурхан”, Эхэн босго”, Одонт манал”, Батцэцэн ӨЭМТ-дэд 144.4 сая төгрөгийн 4ш суудлын автомашин
2024.03.05 A/239 захирамж (18.9 сая төгрөгийн 1 ачааны машин)	-Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ-т Киа бонго маркийн ачааны машин
2024.03.19 A/282 захирамж (41.4 тэрбум төгрөгийн 150 автобус)	- НЗДТГ-т бүртгэх Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нэг бүрийн үнэ 275.9 сая төгрөгийн их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус

Тээврийн хэрэгсэл балансаас баланст шилжүүлэх

2024.01.19 A/86 захирамж (63.7 тэрбум төгрөгийн 231 автобус)	- Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т 27.6 тэрбум төгрөгийн 100 ш их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус, - Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 4.4 тэрбум төгрөгийн 16 ш их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус, - УБ хотын Хөгжлийн корпораци ХК-д 31.7 тэрбум төгрөгийн 115 ш их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус
2024.02.13 A/161 захирамж (60.1 тэрбум төгрөгийн 218 автобус)	- УБ хотын Хөгжлийн корпораци ХК-д 31.7 тэрбум төгрөгийн 218 ш их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус

Барилга байгууламж бүртгэх

2024.01.25 A/36 захирамж (7.9 тэрбум төгрөгийн 5 барилга, 59.0 сая төгрөгийн 2 гүний худаг)	- 2022 онд ашиглалтад орсон СХД-ийн 79-р цэцэрлэг, СБД-ийн 281-р цэцэрлэг, ХУД-ийн 28, 324, 326-р цэцэрлэгүүдийн барилга - 2023 онд ашиглалтад орсон 59.0 сая төгрөгийн СХД-ийн 21-р хороонд байрлах 2 ш гүний худаг,
2024.01.16 A/48 захирамж (308.5 сая төгрөгийн 2 барилга, байгууламж)	- 2023 онд ашиглалтад орсон Ус сувгийн удирдах газарт 130.4 сая төгрөгийн 1 ус түгээх байр, - 2022 онд ашиглалтад орсон БНД-ийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд 178.1 сая төгрөгийн 1 халуун усны барилга, байгууламж

Ажлын хэсэг байгуулах

- 2024.02.07
A/148 захирамж - Барилга, Хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.03.07-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар УБ хотын ус, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээ, түүний эзэмшил, ашиглалтыг тогтоох, дундын өмчлөлийн болон маргаантай шугам сүлжээний эзэмшигч, ашиглагчийг тодорхой болгох үүрэг бүхий ажлын хэсэгт оролцож санал дүгнэлт боловсруулан ажилласан. *Хэрэгжилтийн үр дүнг тооцох хугацаа болоогүй*
- 2024.02.09
A/157 захирамж - Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем “UB ENGINEERING”- ийг ашиглалтад оруулах, журам боловсруулах ажлын хэсгийн хуралд нийслэлийн өмчийн бүртгэлийн мэдээллийг дэд системд тусгах тухай техникийн шаардлагуудын хэлэлцүүлэн, ЗАА-нд саналыг албан бичгээр хүргүүлсэн. “UB ENGINEERING”-ийг 2024.05.01-ний өдрийн дотор ашиглалтад оруулахаар заасан байна. *Хэрэгжилт 70%*
- 2024.02.19 A/159
захирамж - Нийслэлийн өмчит зарим байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, техникийн комиссын актаар ашиглалтын шаардлага хангахгүй, сэргээн засварлаж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон, акталж данс бүртгэлээс хасуулах санал ирүүлсэн тээврийн хэрэгслийн байдалтай газар дээр нь танилцаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан тайланг НЗДТГ-ын даргад танилцуулсан. *Хэрэгжилт 100%*

3. Дүгнэлт

Тайлант хугацаанд нийслэлийн Засаг даргын 13 захирамж 100% буюу “Бүрэн хэрэгжсэн”, ажлын хэсэг байгуулах тухай 1 захирамж (№А/157) 70% буюу “хэрэгжих шатанд”, 6 захирамжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, нийт 14 захирамжийн хэрэгжилтийн дундаж **97.9%** үнэлэгдлээ.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/52 дугаар захирамжаар баталсан “Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам”-ын 9.4-т заасны дагуу хугацаа заасан ажлын хэсэг байгуулсан А/157 дугаар захирамжийн хэрэгжилтийг дүгнэн, батлагдсанаас хойш 3 сар хугацаа өнгөрөөгүй 6 захирамжийн (А/148, А/300-А/304), үр дүнг тооцоогүй болно.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 10 захирамжаар 177.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөн хийх ажлын зохион байгуулж өмч эзэмшигч байгууллагуудад захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг албан бичгээр мэдэгдсэн байна. Үүнд:

- 8 захирамжаар 168.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 599 их багтаамжийн дизель хөдөлгүүртэй Yutong ZK6116HG загварын автобус, 11 хүнд даацын тээврийн хэрэгсэл, 10 суудлын тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгүүлэх, үүнээс 2 захирамжаар 449 автобусыг 3 нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст шилжүүлэх,

- 2 захирамжаар 8.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 7 барилга байгууламж, 59.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 гүний худаг бүртгэх зэрэг

Нийслэлийн Засаг даргын 3 захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласнаас санал дүгнэлт боловсруулан ажилласан (А/148), техникийн саналыг ЗАА-нд хүргүүлсэн (А/157), 103 тээврийн хэрэгслийг газар дээр нь үзэж, тайланг ЗДТГ-ын даргад хүргүүлсэн (А/159) байна.

4.Цаашид авах арга хэмжээний санал

Нийслэлийн Засаг даргын 2024 оны захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийн дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- НИТХТ-ийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам”-ын 7.4. “Хуулийн этгээд нь шинээр олж авсан, бүртгэсэн, акталсан, шилжүүлсэн, худалдсан эд хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор өмчийн бүртгэлийн цахим системд оруулж, Төрийн өмчийн хороо, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр Өмчийн харилцааны газарт ирүүлнэ.”, 7.5. “Өмчийн харилцааны газар нь өмч, хөрөнгийн хөдлөл өөрчлөлттэй холбоотой шийдвэрийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна.” заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах (ӨМХ, ӨБМХ),

- Нийслэлийн засаг даргын хөрөнгийн хөдөлгөөн бүхий 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/300, А/301, А/302, А/303, А/304 дүгээр захирамжийн хэрэгжилтийг 2024 оны 04 дүгээр сард багтаан ханган ажиллах (ӨМХ, ӨБМХ),